



# ЗАВХАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2018 он

Уг тайланг [WWW.AUDIT.MN](http://WWW.AUDIT.MN) сайтаас үзнэ үү.

Аудитын тайлан, дүгнэлттэй  
холбоотой асуудлаар нэмж  
тодруулах, асууж лавлах зүйл  
байвал 70463783, 70463612  
дугаарын утсаар харилцана уу

ХАЯГ: Завхан аймаг дахь  
Төрийн Аудитын газар  
Улиастай сум, Жинст багийн  
Нутгийн захиргааны ордон  
309, 310 тоот өрөө

**Гүйцэтгэсэн:**

Ахлах аудитор

Б.Дагвасүрэн

Аудитор Н.Батбилэг

**Хянасан:**

Дарга, Тэргүүлэх  
аудитор Л.Уламбаяр

Аудитын менежер

Г.Хашцэцэг

2018.04.19

<p><i>Тайланг хянасан:</i> Завхан аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p><i>Дарга дарга, Тэргүүлэх аудитор:</i> <i>Л.Уламбаяр</i></p> <p><i>Аудитын менежер:</i> <i>Г.Хашцэцэг</i></p> <p><i>Тайланг бэлтгэсэн:</i></p> <p><i>Ахлах аудитор:</i> <i>Б.Дагвасүрэн</i></p> <p><i>Аудитор:</i> <i>Н.Батбилэг</i></p> <p><i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 99014227, 96775592 дугаарын утасаар харилцана уу.</i></p> <p><b>ХАЯГ:</b> Завхан аймаг дахь Төрийн аудитын газар. Нутгийн удирдлагын ордон Өрөө №309,310</p>	<p><b>АГУУЛГА</b></p> <p><b>АУДИТЫН ТАЙЛАН</b></p> <p>Аудит хийсэн үндэслэл, хугацаа, зорилт, хамарсан хүрээ, арга зүй</p> <p>Аудитын дүн <span style="float: right;">3</span></p> <p>Зорилт1. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн талаар</p> <p>Зорилт 2. Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, зардлын хэтрэлт, хэмнэлтийн талаар</p> <p>Зорилт 3. Аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайлан болон харъяа байгууллагуудын СТБ-ын дүнгийн талаар</p> <p>Дүгнэлт <span style="float: right;">34</span></p> <p>Зөвлөмж <span style="float: right;">35</span></p> <p>Тайлан баталгаажуулсан тушаал <span style="float: right;">36</span></p> <p>Хавсралт судалгаа</p>
---	---

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖМС	Жижиг мөнгөн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОН	Орон нутаг
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
СТАУС	Санхүүгийн тайлангийн удирдлагын сиситем
СХС	Сум хөгжүүлэх сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
УХӨТ	Урт хугацаат өр төлбөр
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХО	Хөрөнгө оруулалт
ЭМТ	Эрүүл мэндийн төв

## Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### Аудит хийсэн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2,18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/05 тоот туушаалыг үндэслэн Завхан аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аудит хийлээ.

### Аудитын зорилт, хамарсан хүрээ

Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт
- Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, зардлын хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан болон харьяа орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын СТБ-ын дүнгийн талаар
- Төсвийн гүйцэтгэлийн хавсралт судалгаа гаргах

Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах тайлангуудыг хамруулан нэгтгэн гаргав. Үүнд:

- ✓ Сумын Төсвийн ерөнхийлөн захирагчдын 25 санхүүгийн нэгтгэсэн тайлан
- ✓ Орон нутгийн төсөвт 63 байгууллагуудын
- ✓ Тусгай зориулалтын шилжүүлгийн 115 байгууллагын
- ✓ Орон нутгийн өмчит үйлдвэрийн 4 газрын
- ✓ ОНХС, Сум хөгжүүлэх сангуудын 49 нийт 256 байгууллагын санхүүгийн тайланг хамруулав.

### Аудитын арга зүй

Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, хяналтын

сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв.

**Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:**

Үүнд:

- ❖ Төсвийн тухай хууль
- ❖ Монгол улсын 2017 оны төсвийн тухай хууль
- ❖ Төсвийн тухай хуулийн 54.1-54.4 заалт
- ❖ Төрийн аудитын тухай хууль
- ❖ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 69 дүгээр тогтоол
- ❖ Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29, 67 дугаар тогтоол
- ❖ Сангийн сайдын 2017 оны 216, 341 дүгээр тушаал
- ❖ УСНББОУС-д заасан зарчим, УСННББОУС-6 /нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан”
- ❖ Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд
- ❖ Холбогдох бусад хууль тогтоомж

**Аудит хийсэн хугацаа:**

Аудитыг 2018 оны 4-р сарын 05-наас эхэлж 4-р сарын 18-нд хийв.

## АУДИТЫН ДҮН

### Нэг. Төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

**Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 123.5 хувиар буюу 1775.7 сая төгрөгөөр давж биелсэн, татварын давсан орлогыг нэр төрлөөр тодотгон баталж өгөөгүй зардлыг тодотгон баталсан байна.**

**1.1 Төсвийн орлогын төлөвлөлтийн талаар:** УИХ-аас баталж, Сангийн яамнаас хуваарилан хянаснаар 2017 онд орон нутгийн орлогоор 6691.4 сая төгрөг оруулах төлөвлөгөө ирүүлснийг аймгийн ИТХ-ын 2016.12.02-ны өдрийн хуралдааны 19 тоот тогтоолоор аймагт төвлөрөх татварын орлогыг 4942.3 сая, татварын бус орлогыг 386.1 сая, хөрөнгийн албан татвар 423,0 сая, өмчийн татвар 84,7 сая, бусад албан татвар 994.2 сая төгрөгөөр, аймгийн дүнгээр нийт 6830.3 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн нь Сангийн яамнаас хуваарилан хянасанаас 138.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь Төрийн аудитын байгууллагаас аймгийн орон нутгийн орлогыг нэмэгдүүлэхээр оруулсан саналын дүн байна */төсөвт байгууллагын өөрийн орлого орсон 8.6 сая төгрөг/*.  
 Үүнд:

*Хүснэгт-1 /сая.төг-р/*

Татварын нэр төрөл	2017 оны СЯ-ны хянасан суурь	Аймаг, сумын ИТХ-ын анх баталсан дүн	Зөрүү
Нийт орлогын дүн	6691.4	6830.3	138.9
Татварын орлогын дүн	4942.3	4942.3	-
<b>Хөрөнгийн албан татвар</b>	423	423	-
<b>Бусад татвар /төлбөр хураамж/</b>	972.5	994.2	21.7
Татварын бус орлого	353.6	386.1	32.5
Өмчийн татвар		84.7	84.7

*Сангийн яамнаас хянасан 2017 оны суурь орлогын төлөвлөгөөг 138.9 сая төгрөгөөр нэмэгдүүлснийг нэр төрлөөр нь авч үзвэл: Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг 1.5 сая, газрын төлбөрийг 17.9 сая, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 2.3 сая, нэр заагдаж ангилагдаагүй бусад орлогыг 32.5 сая, орон нутгийн өмчийн орлогыг 84.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, бусад татварын орлогыг СЯ-ны хянасан сууриар баталжээ.*

*Сумд татварын орлогын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй.*

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Татварын хэлтсийн төсвийн орлогын мэдээтэй тулган шалгахад зөрүү илрээгүй болно.

**Орон нутгийн татварын орлогод орсон өөрчлөлт**

Тодотгол-1

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн**

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2017.06.09-ны өдрийн 21 тоот тогтоолоор 2016 оны жилийн эцсийн үлдэгдэл 723.1 сая төгрөгийн орлогыг тодотгон баталсан байна. Үүнд:

Хүснэгт-2 /сая.төг-р/

Сумд, байгууллагын нэр	Анх баталсан төсөв	Тодотгосон төсөв	зөрүү
Аймгийн ИТХ	255.4	295.7	40.3
Аймгийн ЗДТГ	1073.5	1364.0	290.5
Сумдын ЗДТГ	5605.4	5671.4	66
Санхүүгийн хяналт дотоод аудитын алба	97.0	123.6	26.6
Хот тохижилт үйлчилгээний алба	353.9	358.9	5
Байгаль орчин аялал жуулчлалын газар	439.4	472.1	32.7
Тосонцэнгэл ойн анги	28.5	45.9	17.4
Аймгийн Засаг даргын нөөц сан	265.5	410	144.5
6 Сумдын ОНХС-г тодотгосон	524.8	626.8	102.0
<b>ДҮН</b>	<b>8643.4</b>	<b>9368.4</b>	<b>723.1</b>

Хүснэгт-3

д/д	Орлого, зардлын нэр төрөл	Анх батлагдсан /сая.төг-р/	Тодотголоор /сая.төг-р/	Зөрүү
1	Аймгийн татварын болон татварын бус орлого	6821.7	6821.7	0
2	Аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	9359.3	9356.2	-3.1
2	Аймгийн төсөвт улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	35822.1	35775.9	-46.2
3	Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	1996.3	1729.7	-266.6
	<b>ДҮН</b>	<b>53999.4</b>	<b>53683.5</b>	<b>-315.9</b>

Дээрх тодотголоос дүгнэхэд урьд оны үлдэгдлийг тодотгосон ч улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 315.9 сая төгрөгөөр буурч батлагдсан байна.



Аймгийн ИТХ-ын хуралдааны 2017.12.04-ны өдрийн 29 тоот тогтоолоор орон нутгийн байгууллагуудын санхүүжилтийн орлогыг 1121.5 сая төгрөгөөр, тусгай шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийн орлогыг 1880.1 сая төгрөгөөр нийт 3001.4 сая төгрөгөөр зардлыг тодотгон баталсан байна.

Хүснэгт -4

№	Сумдын нэр	Анх баталсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү
1	Аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	9356.2	10477.5	1121.3
2	Аймгийн төсөвт улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	35775.9	37656.0	1880.1
	НИЙТ	45132.1	48133.5	3001.4

Орлогыг нэмэгдүүлэн батлахдаа: Татварын орлогын давсан хэсгийг зүйл ангиар нэмэгдүүлэн тодотгон баталж өгөөгүй орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын зарлагыг шууд тодотгон баталсан байна.

Хүснэгт-5

д/д	Орлого, зардлын нэр төрөл	Анх батлагдсан /сая.төг-р/	2017.06.09-н / тодотгол 21/	2017.12.04 /тодотгол/	Нийт тодотгосон төсөв
1	Аймгийн татварын болон татварын бус орлого	6821.7			6821.7
2	Аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	9359.3	-3.1	1121.3	10477.5
2	Аймгийн төсөвт улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	35822.1	-46.2	1880.1	37656.0
3	Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	1996.3	-266.6		1729.7
4	тусгай зориулалтын шилжүүлгийн өөрийн орлого	194.1	7.9		202.0
5	Орон нутгийн байгууллагуудын өөрийн орлого	20.2	5.0		25.2
	ДҮН	54213.7	-328,8	3001.4	56886,3

Татварын орлогын гүйцэтгэлийн талаар:

Хүснэгт-6

Орон нутгийн татварын орлогыг		Гүйцэтгэл			
Бусад татвар	Татварын төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	Биелэлтийн /хувь/	зөрүү
	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос	315.0	851.3	270.24	536.3
	Үйл ажиллагааны орлогын албан татвар	295.0	74.4	25.23	-220.6
	Иргэдийн хадгаламжийн хүүгийг орлого	0.0	315.4	0.00	315.4
	Галт зэвсгийн албан татвар	48.0	51.5	107.26	3.5
	<b>Дүн</b>	<b>658.0</b>	<b>1292.6</b>	<b>196.44</b>	<b>634.6</b>



**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн**

	Улсын тэмдэгтийн хураамж	205.0	163.9	79.93	-41.1
	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	6.5	72.0	1100.76	65.4
	Ойн нөөц ашигласны төлбөр	225.0	239.1	106.29	14.1
	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.0	49.0	0.00	49.0
	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	7.8	80.9	1037.20	73.1
	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	12.0	9.9	82.46	-2.1
	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	90.0	120.0	133.33	30.0
	<b>Дүн</b>	<b>546.3</b>	<b>734.8</b>	<b>134.50</b>	<b>188.5</b>
<b>Татварын бус орлого</b>	Хүү торгуулийн орлого	60.0	85.7	142.77	25.7
	Нэр заагдаагүй бусад орлого	317.5	538.9	169.74	221.4
	<b>Дүн</b>	<b>377.5</b>	<b>624.6</b>	<b>165.45</b>	<b>247.1</b>
	<b>Сумын төсвийн орлогын дүн</b>	<b>1581.8</b>	<b>2652.0</b>	<b>167.65</b>	<b>1070.2</b>
<b>Аймгийн төсвийн орлого</b>	Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад орлого	5157.3	5382.2	104.36	224.9
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	120.0	541.0	450.83	421.0
	АТБӨЯХ-ийн албан татвар	255.0	279.9	109.75	24.9
	Усны нөөц ашигласны төлбөр	245.0	291.1	118.83	46.1
	Газрын төлбөр	202.9	191.6	94.42	-11.3
	<b>Аймгийн төсвийн орлогын дүн</b>	<b>5980.2</b>	<b>6685.7</b>	<b>111.80</b>	<b>705.5</b>
	<b>Орон нутгийн төсвийн орлогын дүн</b>	<b>7562.0</b>	<b>9337.7</b>	<b>123.48</b>	<b>1775.7</b>

**Давсан орлогын талаар**

- Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого, суутгаагчийн хувь хүнд олгосон орлогын татвар 761.1 сая төгрөгөөр давж биелэсэн нь УИХ-ын 2017.11.09-ны 67 дугаар тогтоолоор олгосон төрийн албан хаагчдад олгосон урамшуулал, нөгөө талаас үйл ажиллагааны орлогын албан татвар гүйгдэн тайлагнагдсантай холбоотойгоор
- Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого 315.4 сая төгрөгөөр давж биелсэн нь 2017.05.01-ээс хууль хэрэгжиж эхэлсэн /ХХОАТ-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1-р заалт/
- Үл хөдлөх хөрөнгийн татвар 421,0 сая төгрөгөөр давж биелсэн нь Баян-айраг Эксплорейшнд татварын хяналт шалгалт хийж, үл хөдлөх хөрөнгөнд актын төлбөр тавигдсан
- Нэр заагдаагүй бусад орлого 221.4 сая төгрөгөөр давж биелсэн нь Төрийн аудитын газрын 182.2 сая төгрөг, Цагдаагийн газрын 186.8 сая төгрөг, Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 135.1 сая төгрөгийн төлбөрийн актууд барагдсантай тус тус холбоотой байна.
- Бусад татварын орлогууд 477.8 сая төгрөгөөр давж биелжээ.

**Тасарсан орлогын талаар**

- Улсын тэмдэгтийн хураамж 41.1 сая төгрөгөөр тасарсан нь төлөвлөлт өндөр батлагдсантай
- ТТАМАТөлбөр 2.1 сая төгрөгөөр тасарсан нь аймаг орон нутгийн хөрөнгө оруулалтын ажил багассантай
- Үйл ажиллагааны орлогын албан татвар 220.6 сая төгрөгөөр тасарсан дүнтэй байгаа нь энэ төрлийн татвар суутгаагчийн хувь хүнд олгосон орлогод гүйгдэн тайлагнагдсантай тус тус холбоотой
- Газрын төлбөр 11.3 сая төгрөгөөр тасарсан нь аймаг, сумдын газрын байцаагч нарын ажлын хариуцлага, ажлын хоорондын уялдаа хангалтгүйгээс шалтгаалсан гэж дүгнэж байна.

Орон нутгийн байгууллагуудаар орлогыг авч үзвэл Нийт давсан орлогын 50% буюу 884.9 сая төгрөг нь сумдаас оржээ. Үүнд: Хүснэгт-7

Сумын төсвийн орлогын дүн / мянган .төгрөгөөр/					
	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	биелэлтийн хувь
1	Алдархаан	27230.0	28995.4	1765.4	106.5
2	Асгат	25820.0	31362.4	5542.4	121.5
3	Баянхайрхан	37720.0	48654.1	10934.1	129.0
4	Баянтэс	32665.0	40086.6	7421.6	122.7
5	Дөрвөлжин	56160.0	93685.5	37525.5	166.8
6	Завханмандал	26110.0	28841.4	2731.4	110.5
7	Идэр	61455.0	69968.9	8513.9	113.9
8	Их-Уул	80770.0	205290.0	124520.0	254.2
9	Нөмрөг	28198.0	62869.6	34671.6	223.0
10	Отгон	22920.0	37138.0	14218.0	162.0
11	Сантмаргаз	23908.0	36990.2	13082.2	154.7
12	Сонгино	35460.0	49845.6	14385.6	140.6
13	Тосонцэнгэл	131680.0	226285.6	94605.6	171.8
14	Түдэвтэй	32956.0	40520.6	7564.6	123.0
15	Тэлмэн	32805.0	53077.6	20272.6	161.8
16	Тэс	35861.0	55576.6	19715.6	155.0
17	Ургамал	24638.0	29636.8	4998.8	120.3
18	Улиастай	595403.0	921910.9	326507.9	154.8
19	Цагаанхайрхан	23048.0	39777.9	16729.9	172.6
20	Цагаанчулуут	21490.0	27413.5	5923.5	127.6
21	Цэцэн-уул	27595.0	36694.1	9099.1	133.0
22	Шилүүстэй	24800.0	55418.6	30618.6	223.5
23	Эрдэнэхайрхан	30258.0	103900.9	73642.9	343.4
24	Яруу	33820.0	34795.4		102.9
	<b>Нийт дүн</b>	<b>1472770.0</b>	<b>2358736.2</b>	<b>884990.8</b>	

Орон нутгийн сумдын орлогууд 2.9-243,4 сая төграгаар давж биелсэн байна.

## 1.2 Төсөвт байгууллагын өөрийн орлогын талаар:

Аймгийн дүнгээр төсөвт байгууллагын өөрийн орлогоор 2870.5 сая төгрөг оруулахаас 2130.1 сая төгрөг оруулж 740.4.сая төгрөгөөр төлөвлөгөө тасарсан байна.

### Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт -8 /сая.төг-өөр/

Орлого, зардлын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тодотгосон төлөвлөгөөнөөс	Хувь
тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлого	202.00	250.00	48.00	123.76
Орон нутгийн байгууллагуудын өөрийн орлого	25.20	78.90	53.70	313.10
СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн орлого	2,146.20	1,379.40	(766.80)	64.27
ОНХС-ийн зээлийн эргэн төлөлтийн орлого	497.10	421.80	(75.30)	84.85
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,768.90			
<b>Дүн</b>	<b>5,639.40</b>	<b>2,130.10</b>	<b>(740.40)</b>	<b>585.98</b>

2017 онд Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 2146.2 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 1379.4 сая төгрөг оруулж орлогын төлөвлөгөө 766.8 сая төгрөгөөр тасарч энэ нь аймгийн нийт орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн байна.

### Хоёр. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, зардлын хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар батлагдсан төсөвт зардлыг төлөвлөгөөнөөс 3.2% буюу 1977.8 сая төгрөг хэмнэж, орон нутгийн төсвийн байгууллагууд 362.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.1. 2017 онд аймгийн ИТХ-ын ээлжит хуралдаанаас төсөвт 2 удаа тодотгол хийж, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгээр 10606.5 сая төгрөг, ОНХС-гийн шилжүүлгээр 1708.7 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 37650.7 сая төгрөг авах, орон нутгийн татварын орлогоос 7729.5 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 202.0 сая төгрөг, орон нутгийн байгууллагуудын өөрийн орлогоор 25.2 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн орлого 497.1 сая төгрөг, СХС-ийн орлогоор 2146.2 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 2768.9 сая төгрөг нийт 63334.7 сая төгрөгийг зарцуулахаар төсөв батлагдсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 10606.5 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 37656.14 сая төгрөгийг авч, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 1708.66 сая төгрөг, орон нутгийн татварын орлогоор 8562.6 сая төгрөг, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 2130.1 сая төгрөгийн нийт 60664.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 61356.95 сая төгрөгийг зарцуулжээ.

Төсвийн төлөвлөгөөг хянаж дүгнэхэд батлагдсан төлөвлөгөөнөөс 2670.7 сая төгрөг дутуу санхүүжсэн харагдавч энэ нь урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх 2768.9 сая төгрөгийн төлөвлөгөө нөлөөлсөн байна.

Төсвийн зарцуулалтыг хянаж үзэхэд 61356.9 сая төгрөгийн зардал гаргаж батлагдсан төлөвлөгөөнөөс 3,2 % буюу 1977.8 сая төгрөг хэмнэсэн дүнтэй, бүрдүүлсэн нийт орлогоос 692.8 сая төгрөгөөр илүү зарцуулсан байгаа нь мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс зарцуулагджээ.

Төсөвт байгууллагуудын төсвийн зардлын зарцуулаагүй үлдсэн харилцах дансны үлдэгдэл 906.7 сая төгрөг буюу 362.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хүснэгт -9 /сая.төг-өөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>63,334.75</b>	<b>61,356.95</b>	<b>1,977.80</b>	<b>96.88</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>57,208.12</b>	<b>56,725.07</b>	<b>483.05</b>	<b>99.16</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>45,214.31</b>	<b>44,823.87</b>	<b>390.45</b>	<b>99.14</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>28,807.23</b>	<b>28,627.54</b>	<b>179.69</b>	<b>99.38</b>
210101	Үндсэн цалин	23,688.05	23,726.04	-37.99	100.16
210102	Нэмэгдэл	2,689.59	2,508.89	180.70	93.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	63.24	60.87	2.38	96.24
210104	Урамшуулал	1,034.89	1,051.69	-16.79	101.62
210105	Гэрээт ажлын хөлс	1,331.45	1,280.05	51.40	96.14
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>3,180.44</b>	<b>3,160.72</b>	<b>19.72</b>	<b>99.38</b>
210201	Тэтгэврийн даатгал	2,031.32	2,190.55	-159.23	107.84
210202	Тэтгэмжийн даатгал	270.58	223.84	46.73	82.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	246.53	218.34	28.19	88.57
210204	Ажилгүйдлийн даатгал	57.46	55.72	1.74	96.98
210205	Эрүүл мэндийн даатгал	574.56	472.26	102.31	82.19
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>5,475.88</b>	<b>5,448.70</b>	<b>27.19</b>	<b>99.50</b>
210301	Гэрэл, цахилгаан	416.08	373.22	42.86	89.70
210302	Түлш, халаалт	4,864.13	4,915.32	-51.19	101.05
210303	Цэвэр, бохир ус	188.67	151.57	37.10	80.34
210304	Байрны түрээс	7.01	8.58	-1.58	122.47
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,316.31</b>	<b>1,360.43</b>	<b>-44.12</b>	<b>103.35</b>
210401	Бичиг хэрэг	136.56	178.13	-41.57	130.44
210402	Тээвэр, шатахуун	821.29	860.95	-39.66	104.83

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	140.09	124.46	15.63	88.84
210404	Ном, хэвлэл	46.92	17.04	29.88	36.32
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	62.07	44.85	17.23	72.25
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	109.38	135.00	-25.62	123.43
2105	<b>Нормативт зардал</b>	<b>2,605.70</b>	<b>2,572.85</b>	<b>32.85</b>	<b>98.74</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	314.07	337.94	-23.87	107.60
210502	Хоол, хүнс	2,160.50	2,110.44	50.06	97.68
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	131.13	124.47	6.66	94.92
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>391.99</b>	<b>473.85</b>	<b>-81.87</b>	<b>120.89</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	33.58	30.53	3.05	90.91
210602	Тавилга	0.00	0.00	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00	0.00	0.00
210604	Урсгал засвар	358.40	443.32	-84.92	123.69
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>237.27</b>	<b>230.55</b>	<b>6.73</b>	<b>97.17</b>
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	237.27	230.55	6.73	97.17
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00	0.00	0.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,056.25</b>	<b>978.52</b>	<b>77.73</b>	<b>92.64</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,007.91	947.19	60.72	93.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9.77	8.47	1.30	86.71
210803	Даатгалын үйлчилгээ	8.14	7.64	0.51	93.79
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3.55	3.27	0.27	92.30
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1.36	1.05	0.31	77.01
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9.38	7.83	1.55	83.52
210807	Газрын төлбөр	1.12	1.01	0.12	89.73
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.02	2.06	12.96	13.71
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	0.00	0.00	0.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,143.25</b>	<b>1,970.72</b>	<b>172.53</b>	<b>91.95</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,085.71	1,918.07	167.64	91.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	57.54	52.66	4.88	91.51
211	<b>ХҮҮ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	0.00	0.00	0.00
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	0.00	0.00	0.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	0.00	0.00	0.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	0.00	0.00	0.00
212	<b>ТАТААС</b>	<b>39.28</b>	<b>29.50</b>	<b>9.78</b>	<b>75.10</b>
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	0.00	0.00	0.00	0.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	0.00	0.00	0.00	0.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	39.28	29.50	9.78	75.10
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	39.28	29.50	9.78	75.10
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,954.53</b>	<b>11,871.70</b>	<b>82.83</b>	<b>99.31</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00	0.00	0.00

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн**

213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,954.53	11,871.70	82.83	99.31
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	0.00	0.00	0.00	0.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	7,011.22	6,944.53	66.69	99.05
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	554.40	476.46	77.94	85.94
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	653.84	660.47	-6.63	101.01
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.00	0.00	0.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	889.46	882.98	6.48	99.27
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,693.90	1,692.42	1.48	99.91
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,151.70	1,214.83	-63.14	105.48
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,941.38</b>	<b>3,155.26</b>	<b>786.12</b>	<b>80.05</b>
220001	Барилга байгууламж	0.00	0.00	0.00	0.00
221001	Их засвар	302.21	302.21	0.00	100.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	0.00	0.00	0.00
223001	Бусад хөрөнгө	3,639.17	2,853.06	786.12	78.40
224001	Стратегийн нөөц хөрөнгө	0.00	0.00	0.00	0.00
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>2,185.25</b>	<b>1,476.62</b>	<b>708.63</b>	<b>67.57</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	2,185.25	1,476.62	708.63	67.57
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл	0.00	0.00	0.00	0.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	0.00	0.00	0.00	0.00
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>63,334.75</b>	<b>60,664.04</b>	<b>2,670.71</b>	<b>95.78</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>37,650.74</b>	<b>37,656.14</b>	<b>-5.40</b>	<b>100.01</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
310002	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	37,650.74	37,656.14	-5.40	100.01
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>20,044.64</b>	<b>20,877.80</b>	<b>-833.16</b>	<b>104.16</b>
320001	Орон нутгийн төсвөөс	18,335.98	19,169.14	-833.16	104.54
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,708.66	1,708.66	0.00	100.00
33	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
34	<b>ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
340001	Хүний хөгжил сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00	0.00	0.00

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн**

35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>5,639.37</b>	<b>2,130.10</b>	<b>3,509.27</b>	<b>37.77</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,830.99	1,952.38	878.61	68.96
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39.48	177.72	-138.24	450.17
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,768.91	0.00	2,768.91	0.00
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
36	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
37	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	0.00	0.00	0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,599.62	-1,599.62	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	906.71	-906.71	0.00
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>24,313.60</b>	<b>21,243.00</b>	<b>3,070.60</b>	<b>87.37</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>176</b>	<b>176</b>	<b>0</b>	<b>100</b>
610001	Төсвийн байгууллага	176	176	0	100
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0	0	0
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>3,612</b>	<b>3,669</b>	<b>-57</b>	<b>101.74</b>
620001	Удирдах ажилтан	336	331	5	98.51
620002	Гүйцэтгэх ажилтан	2,099	2,144	-45	102.14
620003	Үйлчлэх ажилтан	851	882	-31	103.64
620004	Гэрээт ажилтан	326	312	14	97.55
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>20,333.60</b>	<b>17,327.00</b>	<b>3,006.60</b>	<b>85.21</b>
630	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>20,333.60</b>	<b>17,327.00</b>	<b>3,006.60</b>	<b>85.21</b>
630001	Төрийн өмчит ЕБС	20,333.60	17,327.00	3,006.60	85.21
630002	Хувийн ЕБС	0	0	0	0
631	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	0	0	0	0
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага	0	0	0	0
632	<b>МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
632001	Төрийн өмчит МСҮТ	0	0	0	0
632002	Хувийн МСҮТ	0	0	0	0
64	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	0	0	0	0
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	0	0	0	0
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо	0	0	0	0
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>192.00</b>	<b>65.00</b>	<b>127.00</b>	<b>33.85</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	161.00	30.00	131.00	18.63
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	3.00	3.00	0.00	100.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	0	0	0	0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	0	0	0	0
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	0	0	0	0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	0	0	0	0

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн**

<b>650007</b>	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	0	0	0	0
<b>650008</b>	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	0	0	0	0
<b>650009</b>	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6	0	100
<b>650010</b>	Гэрээт ажилтан	20	23	-3	115
<b>650011</b>	Улс төрийн албан хаагч (УТ)	2	3	-1	150

Зардлуудын хэтрэлт хэмнэлтийг бүлгээр нь авч үзвэл: хангамж, бараа материалын зардал 44.1 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 81.8 сая төгрөгөөр хэтэрч бусад бүлгийн зардал 6.7-179.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

## 2.2 Орон нутгийн тусгай шилжүүлгийн талаар

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнд:

- ❖ Сургуулийн өмнөх боловсрол
- ❖ Ерөнхий боловсрол
- ❖ Соёлын үйлчилгээ
- ❖ Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ
- ❖ Газрын харилцаа, кадастр;
- ❖ Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ;
- ❖ Нийтийн биеийн тамир.

Дээрх заалтын дагуу ЭМСС, ХАХНХС, БХБС, БСШУС-ын төсөвт батлагдсан тусгай зориулалтын шилжүүлгийн 37656.1 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутагт байршилтай байгууллагуудад Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасны дагуу олгож бүрэн зарцуулсан байна. Тусгай шилжүүлгийн байгууллагуудын орлогыг дараах байдлаар тодотгон баталсан байна.

Хүснэгт -10 /сая.төг-өөр/

Орлого, зардлын нэр төрөл	Анх батлагдсан /сая.төг-р/	2017.06.09-н/ тодотгол 21/	2017.12.04 /тодотгол/	Нийт тодотгосон төсөв
<b>Аймгийн төсөвт улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг</b>	35822.1	-46.2	1880.2	37656.1

2017 онд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: Үүнд:

Хүснэгт -11 /сая.төг-өөр/

Үзүүлэлт	Нийт дүн	БСШУЯ	ХАХНХЯ	ЭМЯ	БХБЯ
<b>Батлагдсан төсөв</b>	37656.1	32060.8	158.9	5215.5	220.9
<b>Олгосон санхүүжилт</b>	37656.1	32060.8	158.9	5215.5	220.9
<b>Төвлөрүүлсэн</b>	0.0	0.0	0.0	0.0	0.0



Харин БСШУС-ын сайдын 2017.11.27-ны өдрийн 1а/11253 тоот албан бичгийг үндэслэн аймгийн Засаг дарга 2016.12.15-ны а/792 тоот захирамжаар Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-ийн “г”, 42.2.2 дахь хэсгийг үндэслэн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөв хооронд зохицуулалт хийсэн ба мөн Ерөнхий боловсролын сургуулийн багцын санхүүжилтээс 70.5 сая төгрөгийг Соёлын байгууллагуудын санхүүжилтэд 52.9 сая төгрөгийг, сургуулийн өмнөх боловсролд 17.6 сая төгрөгийг тус тус олгосон байна.

## 2.3 Тусгай сан

### 2.3.1 Замын сан:

Авто замын сангийн 2017 оны орлогыг: ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор замын санд 3 төрлийн төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр 227.2 сая төгрөгийг, жолоочийн хариуцлагын даатгалд 25.5 сая төгрөгийг тус тус зарцуулахаар баталсан бөгөөд тайлант хугацаанд төсвийн тодотгол хийгдээгүй байна.

Автозамын санд 2017 онд нийт 252.7 сая төгрөг батлагдаж, авто замын гүүр болон засварын 7 төрлийн ажилд 180.1 сая төгрөг зарцуулагдаж, жолоочийн даатгалд 29.5 сая төгрөгийг зарцуулан, 17.6 сая төгрөгийн үлдэгдэлийг 2017 оны жилийн эцэст орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлжээ. Дараах зөрчил илэрлээ

- ✓ Төлөвлөсөн ажлаас Улаанхаалга дахь амралт, сувиллын газар хүрэх замыг засварлаж гүүр барих 15.0 сая төгрөгийн ажил хийгдээгүй байна.
- ✓ Харин төлөвлөгдөөгүй Хатавчийн давааны замын засвар, урд онд хэрэгжүүлсэн Замын тэмдэг, тэмдэглээг шинэчлэх ажлуудад 88.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

### 2.3.2 Орон нутгийн хөгжлийн сан:

2017 онд тус аймагт ОНХНС-гаас 1996.3 сая төгрөг хуваарилсныг аймгийн ИТХ-ын 2016.12.02-ны өдрийн хуралдааны 19 тоот тогтоолоор баталсан ба Улсын нэгдсэн төсөвт тодотгол хийсэнтэй уялдуулан аймгийн ИТХ-ын 2017.06.09-ны өдрийн хуралдааны 21 тоот тогтоолоор 1729.7 сая төгрөгөөр тодотгон 266.6 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Мөн ИТХ-ын 2017.06.09-ны өдрийн хуралдааны 21 тоот тогтоолоор аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн өмнөх оны үлдэгдлээс сумын орон нутгийн хөгжлийн санд зарцуулахаар 102.0 сая төгрөгийг, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 12 дүгээр сарын 04-ны өдрийн 29 тоот тогтоолоор аймгийн ОНХС-ийн орлогоос 63.0 сая төгрөгийг зарцуулахаар төсвийг тус тус тодотгожээ.

Улсын төсвийн 1708.7 сая төгрөгийн санхүүжилтээс Отгон, Тэс, Дөрвөлжин, Идэр сумдад 97,1 сая төгрөгийг аймгийн ОНХНС-ийн дансаар дамжуулалгүйгээр шууд санхүүжүүлжээ.

2017 оны эхэнд ОНХС нь аймгийн нэгдсэн дүнгээр 816.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба ОНХНСангаас 1708.7 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 142.1 сая, хандив, тусламж бусад орлогоор 1271.6 сая төгрөг орж, нийт 3736.3 сая төгрөгийг төсөл, арга хэмжээ бусад зардалд зарцуулан оны эцэст 202.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Сангийн бусад орлогыг тодруулбал Улиастай сумын ХАУС хороололд иргэдийн оруулсан орлого болон сумдын татварын давсан орлогууд төвлөрсөн байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн зарцуулалтад хийсэн санхүүгийн тайлангийн түүвэр аудитаар зөрчил илрээгүй бөгөөд нийцлийн аудитаар Төсвийн тухай хууль болон ОНХС-ийн хөрөнгийг төлөвлөх, зарцуулах, тайлагнах журмын хэрэгжилтийг бодит байдлаар шалгах болно.

### **2.3.3 Сум хөгжүүлэх**

Аудитаар нийт 24 сумын СХС-уудын үйл ажиллагааг хамруулан түүвэр аудит хийсэн.

Тайлант онд эхний үлдэгдлээс 779.2 сая, зээлийн эргэн төлөлтийн орлогоос 1249.0 сая, хүүгийн орлогоос 67.3 сая, бусад эх үүсвэрээс 64.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, зээл олголтонд 1402.2 сая, бусад зардалд 68.7 сая төгрөг зарцуулан, жилийн эцсийн байдлаар 5159.2 сая төгрөгийн авлага, 689.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Бусад орлогоор 64.4 сая төгрөг бүрдүүлж, бусад зардалд 68.7 сая төгрөг зарцуулсан нь сумдын СХС-ийн дансаар дараах ажил гүйлгээг дамжуулан хийж байгаатай холбоотой байна. Үүнд:

1. Байгаль хамгаалах сангийн орлого, зарлага
2. Азийн хөгжлийн банкнаас 2011 онд малчдад олгосон зээлийн эргэн төлөлт болон буцаан олголт
3. Нөхөн сэргээлт, хайгуультай холбоотой орлого, зардал зэрэг байна.

Аудитаар дараах зөрчил илэрсэн:

1. Нийт авлагын 2065.9 сая төгрөг буюу 40 хувь нь хугацаа хэтэрсэн байгааг алдаа зөрчлөөр тооцож 24 суманд албан шаардлага хүргүүлсэн .
2. Завхан аймгийн СХС-уудын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус сангуудын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж үзэхэд шилэн дансны цахим мэдээллийн сангийн төсөв гүйцэтгэл хэсгийн “Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэл” гэсэн хэсэгт мэдээллийг оруулахаар байгаа хэдий ч сум бүрийн шилэн дансруу орж үзэхэд Алдархаан, Нөмрөг, Сантмаргаз, Сонгино зэрэг сумд орлогын талаарх мэдээллийг оруулсан ч

зарлагын талаарх мэдээллийг оруулаагүй, бусад сумд огт мэдээлэл оруулаагүй зөрчил байна.

### **Эргэлтийн эмийн сан**

Завхан аймгийн Эргэлтийн эмийн сангууд нь аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар тул аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад байдгүй учраас дүгнэлт, судалгааг нэгтгээгүй болно. Эргэлтийн эмийн сангуудад аудитаар 4535.9 сая төгрөгийн зөрчил илэрч 2268.0 сая төгрөгийн алдааг залруулан гаргуулж 2268.0 сая төгрөгийн алдааг залруулахаар 29 заалт бүхий зөвлөмж өгөгдлөө.

Сумдын эргэлтийн эмийн сангуудын санхүүгийн тайлан баталгаажуулалтаар дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар батлагдсан “Эргэлтийн эмийн сангийн ажиллах журам” –ын 1.2-т “Сумдын эргэлтийн эмийн сан нь орон нутгийн өмчид суурилсан хуулийн этгээд байна” гэж заасан боловч хуулийн этгээдийн статусаар ажиллаагүй, гэрчилгээ, тамга тэмдэггүй
2. Сүүлийн 3 жилд санхүүгийн тайлан гаргаж Эрүүл мэндийн газарт нэгтгүүлээгүй, тайлант оны эхний үлдэгдлүүд бодитой эсэхийг тодорхойлох боломжгүй
3. Банкинд тусгай дансгүй, хувь хүний нэрээр данс нээлгэсэн, бэлэн мөнгөний орлогоо дансаар дамжуулж зарцуулаагүй
4. Нягтлан бодох бүртгэл, данс, журнал хөтлөөгүй
5. Яруу сумын Эргэлтийн эмийн сан үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлгүй, мэргэжлийн бус хүн ажиллуулсан

### **2.4 Төсвийн шилжүүлэг**

**Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж:** Нийгмийн халамжийн сангаас 8 төрлийн тэтгэвэр, тэтгэмжид 6582.1 сая, үйл ажиллагааны зардалд 87.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс тэтгэвэр тэтгэмжид 6831.3 сая, үйл ажиллагааны зардалд 43.5 сая төгрөг зарцуулж нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн сангийн зардлыг нийт 205.7 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ нь ИТХ-ын хуралдааны 2017 оны 29 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн сангийн зардалд тодотгол хийсэнтэй холбоотой байна.

### **2.5 Ангилагдаагүй зардал**

2017 оны ангилагдаагүй зардлын дансанд өмнөх оны төвлөрүүлсэн үлдэгдэл буюу улсын төсвөөс өвөлжилтийн хүндрэлтэй холбогдуулж өгсөн 100.0 сая төгрөг, ОБЕГ-аас Отгонтэнгэр уулын осол, үер усны гамшиг осолтой холбоотойгоор 183.6 сая төгрөг нийт 283.6 сая төгрөгийн орлогоос 173.1 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж үлдэгдэл 110.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

## 2.6 Орон нутгийн нэмэлт санхүүжилтийн дансны талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн нэмэлт санхүүжилтын дансаар өмнөх оны үлдэгдэл 172.8 сая, тайлант оны санхүүжилтийн 1528.8 сая төгрөг, нийт 1701.6 сая төгрөгийн орлогоос 1622.2 сая төгрөгийг холбогдох газруудад хуваарилан зарцуулж 79.4 сая төгрөгийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлж байна.

## 2.7 Ажилчдын орон тооны талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар гарсан ажилчдын тоог судалгаатай тулган гаргав.

Хүснэгт -12 /хүнээр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
<b>Ажилчдын тоо</b>	<b>3612</b>	<b>3669</b>	<b>57</b>
Удирдах ажилтан	336	331	-5
Гүйцэтгэх ажилтан	2099	2144	45
Үйлчлэх ажилтан	851	882	31
Гэрээт ажилтан	326	312	-14

Нийт ажилчдын тоог харьцуулан дүгнэхэд өмнөх оноос 57 орон тоо илүү ажилласан байна.

Хүснэгт -13 /хүнээр /

Илүү ажиллаж байгаа орон тоог сумын дүнгээр харуулбал				
ДД	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Алдархаан	81	81	0
2	Асгат	92	93	1
3	Баянтэс	125	127	2
4	Баянхайрхан	110	109	-1
5	Дөрвөлжин	103	104	1
6	Завханмандал	84	88	4
7	Идэр	118	117	-1
8	Их-Уул	207	207	0
9	Нөмрөг	99	101	2
10	Отгон	125	125	0
11	Сантмаргаз	110	114	4
12	Сонгино	104	106	2
13	Тосонцэнгэл	305	311	6
14	Түдэвтэй	96	96	0
15	Тэлмэн	130	130	0
16	Тэс	126	126	0
17	Улиастай	649	654	5
18	Ургамал	95	96	1
19	Цагаанхайрхан	83	86	3
20	Цагаанчулуут	98	98	0
21	Цэцэн-Уул	110	111	1
22	Шилүүстэй	103	102	-1
23	Эрдэнэхайрхан	88	87	-1
24	Яруу	91	92	1
25	Аймгийн төв	280	308	28
	<b>дүн</b>	<b>3,612</b>	<b>3,669</b>	<b>57</b>

Аймгийн дүнг нягталж үзвэл Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний албаны зам талбайн үйлчлэгч, жолоочийн орон тоо 24-өөр илүү байна. Энэ орон тоог 2018 оны төсөвт баталж өгсөн байна.

### **Гурав. Улсын Их хурлын 2017 оны 29, 67 дугаар тогтоолуудын хэрэгжилт**

Төсвийн зарцуулалтыг хянаж үзэхэд 61356.9 сая төгрөгийн зардал гаргаж батлагдсан төлөвлөгөөнөөс 3.2 % буюу 1977.8 сая төгрөг хэмнэсэн дүнтэй төсөвт байгууллагуудын зардлын зарцуулаагүй үлдсэн харилцах дансны үлдэгдэл 906.7 сая төгрөг буюу 362.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн үр дүнтэй байгаа ч төсвийн зардлуудыг хянаж үзэхэд дараахь зөрчил дутагдлууд илэрлээ. Үүнд:

- ❖ Төрийн албан хаагчдад олгосон үр дүнгийн урамшууллын 300.0 мянган төгрөгийг сахилгын шийтгэл ногдуулсан 91 албан хаагчдад олгосон 25.1 сая төгрөгийн төлбөрийн актыг Санхүүгийн хяналт, аудитын алба, 3.4 сая төгрөгийн төлбөрийн актыг Төрийн аудитын газар тогтоожээ.
- ❖ Ерөнхий болосролын сургууль, цэцэрлэгийн эрхлэгч нар өөрсөддөө тушаал гарган үр дүнгийн урамшил, ур чадварын нэмэгдлийг тооцож авсан 62 ажилтны 76.7 сая төгрөгийн төлбөрийн актыг Санхүүгийн хяналт, аудитын алба, Төрийн аудитын газар 6.1 сая төгрөгийн акт тогтоож 11.0 сая төгрөгийн албан шаардлагыг хүргүүлсэн байна.
- ❖ Эрдэнэхайрхан сумын “Хар нуур” дээр зохион байгуулагдсан “Нүүдэлчдийн соёлын их наадам-2017” –орон нутгийн болон тусгай шилжүүлгийн төсвийн 96 байгууллагаас 145.0 сая төгрөгийн зардал гаргасан,
- ❖ Төсвийн хөрөнгөөр 210.4 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 102.0 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 70.9 сая төгрөгийн тавилга эд хогшил нийт 383.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зохих газруудын зөвшөөрлөөр бэлтгэсэн,
- ❖ Бүх сумдын засаг дарга нарт G-380 станцтай утас /29\*250.0 мянган төгрөг/ үйлчилгээний суурь хураамж /30\*84.0 мянган төгрөг/ нийт 9.8 сая төгрөгийн гар утасны зардал гаргасан
- ❖ Аймгийн засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зарцуулалтын 4.7% буюу 42.7 сая төгрөгийг билэг дурсгал, хүлээн авалт, шагнал, урамшуулал эзэлсэн байгаа нь Улсын Их Хурлын 29 дүгээр тогтоолыг зөрчсөн зарцуулалт болсон байна гэж дүгнэлээ.

### **Дөрөв. Санхүүгийн дотоод хяналт**

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн заалтууд, 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу аймгийн ТЭЗ Санхүүгийн хяналт, аудитын албыг 2015 онд байгуулан ажиллуулжээ. Тус алба 2017 онд өөрийн төлөвлөгөөт 14 сумын төсөвт байгууллагууд, Улсын Их хурлын 2017 оны 29, 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хянахаар 24 сум, мөн иргэдээс ирүүлсэн мэдээллийн дагуу сумдад ажиллан 51 удаагийн давталтаар бүх сумдад санхүүгийн хяналт шалгалтыг хийж, төсвийн тухай

хууль, түүнтэй холбогдон гарсан журмын хэрэгжилтийн дүнд нийтлэг илэрсэн зөрчил дутагдлыг засч, сайжруулах чиглэлээр зөвлөмж өгч ажилласан байна.

Үүний үр дүнд 132 ш улсын байцаагчийн актыг бичиж 216.7 сая төгрөгийг орон нутгийн орлогын нэр заагдаагүй орлогод оруулахаар тогтоосон бөгөөд 135.1 сая төгрөг нь дансанд төвлөрсөн байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2017 онд хяналт хийх үйлчилгээний автомашиныг ЗДТГ-аас балансаас балансад шилжүүлэн авч хяналт шалгалтыг хийж байгаа бөгөөд жолооч, нягтлан бодогч, аудитор гэсэн 3 орон тоог шинээр авч тодотголоор 28.4 сая төгрөгийг нэмэгдүүлэн төлөвлөгөөг батлуулсан байна.

Дотоод аудитын ажил нь үр дүнгээ өгсөн, өмнөх жилүүдтэй харьцуулахад санхүүгийн хяналт нь бүх орон нутгийн төсөвт байгууллагуудыг хамарч хийгдэн аудитаар орж байгаа байгууллагуудын санхүүгийн баримтын эмх цэгц сайжирсан төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил багассан харагдаж байна.

**Тав. Шилэн дансны мэдээлэл**

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь “Шилэн дансны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журамын 8.3 заалтыг удирдлага болгон хяналтыг хэрэгжүүлж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийг хугацаанд нь тавьж байгаа эсэх болон мэдээллийн үнэн зөв бодитой байдалд сүлжээгээр тандан судлах, хяналт хийх удирдамж боловсруулан ажиллажээ.

Хүснэгт -14 /тоогоор /

Төсөвт байгууллагын нэр	б/тоо	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо	Мэдээлээгүй тоо				Хугацаа хоцорсон	Хэрэгжилт хувь	Чанар
				Төсөв гүйцэтгэл	ХО, тендер худалдан авалт	Бусад	Дүн			
Төсөвт байгууллагууд	211	30595	30021	302	181	92	574	3850	98.1	85.5
Төсөл хөтөлбөрүүд	25	3425	3260	71	51	43	165	700	95.2	74.74
ТӨХК, ТӨААН, ТӨҮГ, ТӨХХК, ТӨ-тих сургууль, ТӨ-ийн оролцоотой ААН	11	1256	1159	34	35	28	97	349	92.3	64.8
Төсвийн сангууд	3	435	407	17	4	7	28	71	93.6	77.2
Хувийн ААН, худийн сургууль, цэцэрлэг, ӨЭМТ, ЭЭС, Хоршоо, нөхөрлөл, ТББ-ууд	18	72	33				39	14	45.8	26.5
<b>Дүн</b>	<b>268</b>	<b>35783</b>	<b>34880</b>	<b>424</b>	<b>271</b>	<b>170</b>	<b>903</b>			

Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар 211 төсөвт байгууллага, 25 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөл хөтөлбөр, Сайдын төсвийн багцын 3 сан, Төрийн өмчийн 11 ААН, хувийн хэвшлийн 18 аж ахуйн нэгж буюу нийт 268 нэгж байгууллага шилэн дансны нэгдсэн цахим системд бүртгэгдэн мэдээлэл байршуулж байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2017 оны сүүлээр хийгдсэн шалгалтын дүнгээр 268 нэгж байгууллага нийт 35783 удаагийн мэдээлэл байршуулах ёстойгоос 34880 удаагийн мэдээлэл байршуулж хэрэгжилт 97.4 хувьтай байна гэж мэдээлжээ.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал:

- СХС-уудын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй боловч тус сангуудын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж үзэхэд шилэн дансны цахим мэдээллийн сангийн төсөв гүйцэтгэл хэсгийн “Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэл” гэсэн хэсэгт мэдээллийг оруулахаар байгаа хэдий ч сум бүрийн шилэн дансруу орж үзэхэд Алдархаан, Нөмрөг, Сантмаргаз, Сонгино зэрэг сумд орлогын талаарх мэдээллийг оруулсан ч зарлагын талаарх мэдээллийг оруулаагүй, бусад сумд огт мэдээлэл оруулаагүй зөрчил байна.
- Байгууллага бүр админ болон хэрэглэгчийн эрхээр нэвтрэн мэдээлэл байршуулах, байгууллагын болон хувийн мэдээллийг засах эрхтэй байдаг боловч зарим байгууллагууд админ эрхээ ашиглаж мэдээллээ шинэчлээгүй
- Ихэнх байгууллагууд шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээллийн улирлын тайланг цахимаар илгээгээгүй нь Засгийн газрын 2016 оны 29-р тогтоолын 8.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй.
- Мэдээлэл байршуулах хугацааг мөрдөөгүйгээс хугацаа хоцролт маш их байгаа зэрэг зөрчлүүд илэрлээ.

***Хуулийн хэрэгжилт аймгийн хэмжээнд 85.0 хувь, чанар 65.7 хувьтай үнэлэгдэж байгаа нь хувийн аж ахуйн нэгжүүд мэдээлэл хангалтгүй байршуулсан байна.***

Мөн хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн байгууллагын эрх баригч нарт холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлдэг боловч арга хэмжээ авч хариу мэдэгддэггүй, хуулийн хэрэгжилтэнд анхаарч ажилладаггүйтэй холбоотой.

Мэдээллээ хугацаанд нь бүрэн байршуулж хэвшсэн аж ахуйн нэгж байгууллагуудыг урамшуулах, бүртгэл, санхүүгийн ажилчдын ажлын үнэлгээнд шилэн данс хөтлөлтийг нэг үзүүлэлт болгон дүгнэх тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Цаашид анхаарах асуудал:

- ✓ Мэдээллээ хуулийн хугацаанд үнэн зөв байршуулах
- ✓ Хэрэглэгчид нь админ эрхээ ашиглаж байх

- ✓ Тайлангаа улирал бүр илгээж хэвших
- ✓ Шилэн дансны мэдээллийг хэрэглэж, иргэдэд сурталчилах

Өмнөх онтой харьцуулахад шилэн дансны мэдээллийн хувь өссөн нь Санхүүгийн хяналт, аудитын алба, Төрийн аудитын байгууллагаас хяналт тавьж ажиллаж байгаатай холбоотой байна

Төрийн аудитын байгууллагын 2017 оны 10 сард хийсэн Шилэн дансны аудитаар дараахь ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын санхүү төрийн сангийн хэлтэс болон хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс ажлын удирдамж гарган 2017 оны 1, 5, 10 дугаар саруудад мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангуулах зорилгоор байгууллага бүрээр Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянан мэдээлэл байршуулаагүй болон хугацаа хоцроосон, дутуу мэдээлсэн Яруу, Дөрвөлжин сумын төсвийн захирагч, нягтлан бодогчид арга хэмжээ авах албан тоот хүргүүлэн, алдаатай мэдээллүүдийг засах, дутуу мэдээллийг нөхөн байршуулах албан бичгийг аймгийн төвийн 4 байгууллага, 18 сумын 35 байгууллагад хүргүүлэн ажилласан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын алба сангийн яамнаас ирүүлсэн маягтын дагуу улирал бүр судалгаа гарган ажиллаж, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 210 төсөвт байгууллага, 25 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөл хөтөлбөр, Сайдын төсвийн багцын 3 сан, Төрийн өмчийн 12 аж ахуйн нэгж, төсвөөс татаас авсан 17 аж ахуйн нэгж, нийт 267 нэгж байгууллагын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалган 1 сумын ТЕЗ, 3 сумын ИТХ, ЗДТГ, ЭМТ-ийн дарга, эрхлэгч нарт арга хэмжээ тооцуулах албан бичгийг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн ажилласан байна.

2017 оны 11 сарын 13-ны байдлаар албан шаардлагын хариуг 14 байгууллага, аж ахуйн нэгж буюу 53.9 хувь нь ирүүлсэн бөгөөд хэрэгжилтийг шалгахад төсөвт 3 байгууллага, аж ахуйн нэгжүүдээс “Засагт хан констракшн” ХХК бүрэн биелүүлж, албан шаардлагын биелэлт 28,9 хувь байна.

### **Зургаа. Өмнөх оны СТБ-аар тогтоогдсон акт, албан шаардлага, өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийн талаар:**

2016 оны санхүүгийн тайлан баталгаажуулалтаар аймгийн ТЕЗ-д 4 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд 75 хувийн хэрэгжилттэй бөгөөд 1 асуудал хэрэгжилтийн шатандаа байна.

2016 оны санхүүгийн тайлан баталгаажуулалтаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг харуулав



Хүснэгт -15 /сая.төг-өөр/

Актын төлбөр				Албан шаардлага				Зөвлөмж	
Тоо	Өгсөн Дүн /сая.төг-р/	Тоо	Хэрэгжсэн Дүн /сая.төг-р/	Тоо	Өгсөн Дүн /сая.төг-р/	Тоо	Хэрэгжсэн Дүн /сая.төг-р/	өгсөн	хэрэгжсэн
32	259.7	24	254.2	28	612.7	24	581.7	130	130

Актын төлбөр 97.9%, албан шаардлага 94.9%, зөвлөмжийн биелэлт 100 %-тай хэрэгжсэн байна. /биелэлтийг 2017 оны 12 сарын 31-ний мэдээгээр авав/

### Долоо. Материаллаг байдлыг тодорхойлох

Завхан аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлогын 94786.3 сая төгрөгийг суурь болгон авч түүний 1.0 хувиар тооцон 947.8 сая төгрөгөөр тогтоов.

### Найм. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Төсвийн тухай хуулийн 8.9.4-т “Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасны дагуу Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт санхүүгийн нэгтгэсэн тайланг 2017 оны 04-р сарын 03-ны өдөр excel файл, болон цаасан хэлбэрээр ирүүлсэн.

ТЭЗ-ийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан Сангийн сайдын 2017 оны 216, 341 тушаалын дагуу бэлтгэгдсэн бөгөөд иж бүрэн, үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргасан байна.

### Ес. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

#### 9.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2017 оны эцэст 3236.7 сая төгрөг байснаас 22.1 хувиар буурч 2520.9 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 93.9 % нь төрийн сангийн дансанд байршиж байна.

ТЭЗ-ийн төсвийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2017 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Хүснэгт -16 /сая.төг-өөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>	<b>8.019</b>	<b>3.87</b>	<b>-4.149</b>	<b>48.3</b>
Төгрөг/ЖМС	8.0	1.21	-6.79	15.1
Нэмэлт санхүүжилтийн касс	0.019	2.65	2.631	13947.4

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн**

<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>3228.6</b>	<b>2517.1</b>	<b>-711.5</b>	<b>78.0</b>
Төгрөг	3228.6	2517.1	-711.5	78.0
Төрийн сангийн харилцах	2998.1	2369.6	-628.5	79.0
Арилжааны банкин дахь харилцах	57.7	70.8	13.1	122.7
Нэмэлт санхүүжилтийн харилцах	172.8	76.7	-96.1	44.4
Гадаад валют			0	
Замд яваа мөнгөн хөрөнгө			0	
<b>Нийт мөнгөн хөрөнгийн дүн</b>	<b>3236.619</b>	<b>2520.97</b>	<b>715.649</b>	<b>77.9</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:</b>				
Төрийн сан	1439.9	1429.7	-10.2	-0.7
Төсөвт байгууллагууд	817.7	925.8	108.1	13.2
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	49.6	68.9	19.3	38.8
Төсөл, сангууд	929.5	96.5	-833.0	-89.6

Төрийн сангийн 1429.7 сая төгрөг нь аймаг, сумдын Төрийн сангийн харилцах дансан дахь үлдэгдэл... төгрөг, 925.8 сая төгрөг нь сумдын ОНХС, СХС-ийн үлдэгдэл, 96.5 сая төгрөг нь техник хяналтын зардал дансны үлдэгдэл байна.

Арилжааны банкуудад байршиж буй харилцах дансыг хураангуйлан харуулбал:

Хүснэгт-17 /сая.төгрөгөөр/

№	Сумын нэр	Нийт дүн	Үүнээс				Дансны тоо	Үүнээс	
			Төрийн сан	Төсөвт байгууллага	Төсөл сан	ОНӨҮГ		байгаа	хаагдсан
1	Аймгийн төрийн сан	70.70		1.70		69.00	7	7	
2	Цэцэн-Уул	0.03	0.03				1	1	
3	Цагаанхайрхан	0.01	0.01				1	1	
4	Нөмрөг	0.03			0.03		1	1	
5	Сантмаргац	-	-				1	1	
	Нийт дүн	70.77	0.04	1.70	0.03	69.00	11	11	-

Санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг төсвийн байгууллагуудаас хүлээн авсан санхүүгийн тайлантай тулган баталгаажуулахад зөрүү илрээгүй болно.

**Арав. Авлагын бүртгэл, тайлагнал**

**10.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар**

Аймгийн ТЭЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлага тайлант онд 81.2 сая төгрөгөөр өссөн нь хувь хүмүүсээс авах авлага 175.2 сая төгрөгөөр өсч бусад авлага буурч тайлагнагдсан байна.

*Нийт авлагын үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:*

*Хүснэгт-18 (сая.төгрөгөөр)*

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Ажиллагчидтай холбогдсон авлага	36.8	29.0	-7.8	-21.28
Төлбөртэй үйлчилгээний авлага	158.9	158.0	-0.9	-0.58
Дансны авлага /ТӨҮГ/	113.64	48.2	-65.5	-57.60
Татаас санхүүжилтийн авлага	1.23	0.1	-1.2	-95.12
Байгууллагаас авах авлага	207.6	189.0	-18.6	-8.94
Хувь хүмүүсээс авах авлага	5103.8	5279.0	175.2	3.43
<b>НИЙТ ДҮН</b>	<b>5622.0</b>	<b>5703.2</b>	<b>81.2</b>	<b>1.44</b>
<b><i>Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:</i></b>				
Төрийн сан	153.7	153.7	0.0	0.0
Төсөвт байгууллагууд	281.2	5425.2	5144.0	1829.3
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	180.7	124.3	-56.4	-31.2
Төсөл, сангууд	5006.5	0	5006.5	-100.0

*Авлагыг задалж харуулбал:*

- ✓ аймгийн төрийн санд бүртгэлтэй 153.7 сая төгрөг нь 2001 оноос дамжсан эзэн тодорхойгүй
- ✓ Сумдын СХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага 5153.4 сая төгрөг
- ✓ 2010 онд аудитын газрын зөвлөмжөөр үүсгэсэн 87.8 сая төгрөг
- ✓ ОН-ын өмчит үйлдвэрийн газруудын 124.3 сая төгрөг
- ✓ Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын авлага 268.8 сая төгрөгийн авлагууд байна

Нийт авлагыг сум тус бүрээр хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-19 (сая төгрөгөөр)

Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	хувь
Алдархаан	222.3	215.1	-7.2	-3.2
Асгат	169.3	154.6	-14.7	-8.7
Баянтэс	170.6	183.4	12.8	7.5
Баянхайрхан	176.9	173.4	-3.5	-2.0
Дөрвөлжин	136.5	151.4	14.9	10.9
Завханмандал	147.1	180.1	33.0	22.4
Идэр	163.2	159.6	-3.6	-2.2
Их Уул	295.2	290.3	-4.9	-1.7
Нөмрөг	170	162.9	-7.1	-4.2
Отгон	226.2	200.2	-26.1	-11.5
Сантмаргац	142.8	191.2	48.4	33.9
Сонгино	162.8	152.1	-10.7	-6.6
Тосонцэнгэл	508.5	499.1	-9.4	-1.8
Түдэвтэй	142.4	156.2	13.8	9.7
Тэлмэн	145.3	120.2	-25.1	-17.3
Тэс	189.9	230.4	40.5	21.3
Улиастай	882.2	888.7	6.5	0.7
Ургамал	98.6	140.5	41.9	42.5
Цагаанхайрхан	173.7	184.6	10.9	6.3
Цагаанчулуут	182.7	178.0	-4.7	-2.6
Цэцэн-Уул	153.7	137.1	-16.6	-10.8
Шилүүстэй	227.3	232.2	4.9	2.2
Эрдэнэхайрхан	79.1	137.9	58.8	74.3
Яруу	182.3	159.8	-22.5	-12.4
Аймгийн төрийн сан	473.3	424.4	-48.9	-10.3
<b>Дүн</b>	<b>5621.9</b>	<b>5703.2</b>	<b>81.3</b>	<b>1.4</b>

Авлагын насжилтын хувьд олон жил болсон төрийн сангийн авлагыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасан “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй буюу үнэн зөв байдал, толилуулга, эрх ба үүрэг, хэмжилт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй, Сангийн сайдын 388 дугаар тушаалаар баталсан НББ-ийн зааврыг зөрчсөн байна.

**Арван нэг. Бараа материалын бүртгэл, тайлагнал.**

**11.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар**

Аймгийн ТӨЗ-ийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эцсийн үлдэгдэл 5052.9 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 207.5 сая төгрөг буюу 4.2% -иар өссөн байна.

**Нийт бараа материалын үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:**

*Хүснэгт-20 (сая.төгрөгөөр)*

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
Тусгай зориулалтын материал	346.3	452.5	106.2	30.7
Эм боох материал	73.7	74.1	0.4	0.5
Дуусаагүй үйлдвэрлэл	16.5	6.0	-10.5	-63.8
Бэлэн бүтээгдэхүүн	11.8	15.5	3.7	31.4
Бичиг хэргийн материал	230.3	222.9	-7.4	-3.2
Аж ахуйн материал	1223.8	1300.2	76.4	6.2
Сэлбэг хэрэгсэл	56.6	58.3	1.7	3.0
Түлш шатхуун, тослох материал	485.5	460.5	-25.0	-5.1
Барилга засварын материал	114.9	154.8	39.9	34.7
Хүнсний материал	401.2	381.1	-20.2	-5.0
Бусад хангамжийн материал	1491.5	1674.7	183.2	12.3
Мал амьтад	393.3	252.5	-140.8	-35.8
Нөөцийн бараа	0	0.0	0.0	0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>4845.4</b>	<b>5052.9</b>	<b>207.5</b>	<b>5.9</b>
Төрийн сан	0	0	0	0
Төсөвт байгууллагууд	4777.5	4957.8	180.3	3.77
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	68	95.1	27.1	39.85
Төсөл, сангууд	0	0	0	0

Тайлант онд нийт төсвийн болон өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 6591.8 сая төгрөгийн, хандив тусламжаар 265.7, шилжүүлж авсан 24.9 сая төгрөгийн бараа материал байгаа бол бусад хэлбэрээр 43.2 сая төгрөгийн бараа материал нэмэгдүүлж, 6718.8 сая төгрөгийн бараа зарцуулсан байна.

## Арван хоёр. Үндсэн хөрөнгийн талаар

### 12.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар

Аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө 2017 оны эцэст 83291.7 сая төгрөг байгаа нь өмнөх оны үлдэгдлээс 459.2 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна.

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:

Хүснэгт-21 (сая.төг)

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	
			дүн	Хувь
Барилга байгууламж	64940.4	65514.4	574	0.9
Тээврийн хэрэгсэл	2162	2183.2	21.2	1.0
Машин тоног төхөөрөмж	8856.2	7960.4	895.8	-10.1
Тавилга эд хогшил	2757.6	2580.7	176.9	-6.4
Дуусаагүй барилга	19.8	19.8	0	0.0
Зам, гүүрийн байгууламж	9.1	8.3	-0.8	-8.8
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1169.3	1183.9	14.6	1.2
Бусад үндсэн хөрөнгө	2585.8	2469.6	116.2	-4.5
Ном	1231.7	1339.6	107.9	8.8
Биет бус хөрөнгө	18.9	31.8	12.9	68.3
Дүн	<b>83750.9</b>	<b>83291.7</b>	459.2	-0.5
<b>Төрийн сан</b>				
Төсөвт байгууллагууд	76810.7	76596.1	214.6	-0.3
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	6940.2	6695.6	244.6	-3.5
Төсөл, сангууд				

Тайлант онд: 3698.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн

- ✓ хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн хөрөнгө төсөл хөтөлбөрөөр нийлүүлэгдсэн барилга байгууламж 2303.5 сая төгрөг
- ✓ тээврийн хэргэсэл 419.4 сая төгрөг
- ✓ ташин тоног төхөөрмөж 370.9 сая төгрөг
- ✓ тавилга эд хогшил 243.4 сая төгрөг
- ✓ түүх соёлын дурсгалт зүйл 11.2 сая
- ✓ номын фонд 72.5 сая
- ✓ бусад үндсэн хөрөнгө 261.9 сая
- ✓ биет бус хөрөнгө 15.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж

Хасагдсан үндсэн хөрөнгө 1574.8 сая төгрөг

- ✓ Шилжүүлсэн 321.5 сая төгрөг
- ✓ Акталж устагасан 1052.4 сая төгрөг
- ✓ Худалдсан 107.9 сая төгрөг
- ✓ Бусад 93.0 сая төгрөг

Нийт үндсэн хөрөнгийн 78.6 хувь нь барилга байгууламж, 3.0 хувийг тавилга, эд хогшил, 2.6 хувийг машин тоног төхөөрөмж эзэлж байгаа бөгөөд үлдэх 15.8 хувийг бусад үндсэн болон биет бус хөрөнгө тус тус эзэлж байна.

### **Арван гурав. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал**

#### **13.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар**

Аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийг 1902.3 сая төгрөгөөр тайлагнасан нь өмнөх үлдэгдлээс 324.8 сая төгрөг буюу 14.6 хувиар буурсан байна.

*Нийт өр, төлбөрийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:*

*Хүснэгт-22 /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний	Эцсийн	Зөрүү	Хувь
	үлдэгдэл	үлдэгдэл		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>922.6</b>	<b>597.9</b>	<b>-324.7</b>	<b>-35.2</b>
Өглөг	922.6	597.9	-324.7	-35.2
Урьдчилж орсон орлого	-	-	-	
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>1304.4</b>	<b>1304.4</b>	<b>0</b>	<b>0.0</b>
Урт хугацаат үнэт цаас				
Урт хугацаат зээл	1304.4	1304.4	0	0.0
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>2227.1</b>	<b>1902.3</b>	<b>-324.8</b>	<b>-14.6</b>

Өглөгийг задалж харуулбал:

- ✓ УХӨТ-ийн 1304,4 сая төгрөг нь “Амь-Ус трейд” ХХК-ний дамжуулан зээлдүүлсэн Дэлхийн хөгжлийн банкинд төлөх өр
- ✓ Төрийн өмчит үйлдвэрийн газруудын өглөг 332.2 сая төгрөг
- ✓ Төрийн сангийн өглөг 41.6 сая төгрөг
- ✓ Төсөвт байгууллагуудын өглөг 140.1 сая төгрөгийг зэлж байна.

*Өглөгийн үлдэгдлийг сум тус бүрээр задалж харуулбал:*

*Хүснэгт-23 /сая төгрөг*

Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн, буурсан
Алдархаан	0	16.2	16.2
Асгат	0	0.6	0.58

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн**

Баянтэс			0
Баянхайрхан	1.3	0.5	-0.8
Дөрвөлжин	3	0.02	-2.98
Завханмандал	0.9	0	-0.9
Идэр			0
Их Уул	0.1	0.5	0.4
Нөмрөг	35.5	3	-32.5
Отгон			0
Тосонцэнгэл	284.5	44.7	-239.8
Түдэвтэй	0.1		-0.1
Тэлмэн			0
Тэс	12.1	8.2	-3.9
Улиастай	21.5	1.5	-20
Ургамал	1.1	0.1	-1
Цагаанчулуут	14.1	2.7	-11.4
Цэцэн-Уул	16.6		-16.6
Шилүүстэй	9.3	2.9	-6.4
Эрдэнэхайрхан	6.5	3.3	-3.2
Яруу	2.4	0.03	-2.37
<b>Аймгийн төрийн сан</b>	<b>513.7</b>	<b>513.7</b>	<b>0</b>
<b>БХӨТ-ийн дүн</b>	<b>922.7</b>	<b>597.9</b>	<b>-324.77</b>
<b>Аймгийн төрийн сан</b>	<b>1,304.40</b>	<b>1,304.40</b>	<b>0</b>
<b>УХӨТ-ийн дүн</b>	<b>1,304.40</b>	<b>1,304.40</b>	<b>0</b>
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>2,227.10</b>	<b>1,902.33</b>	<b>-324.77</b>

Аймаг, сумын Засаг дарга нар Төсвийн тухай хуулийн 39.4-т “Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхэд дараах шаардлага тавигдана”, 39.4.2-т “Өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

### **11. Хуримтлагдсан үр дүнгийн талаар**

ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант үеийн үр дүн 591.5 сая төгрөгөөр алдагдалтай тайлагнагдсан бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хуримтлагдсан үр дүн 28720.0 сая төгрөг болсон байна.

### **12. Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын талаар**

Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 257 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж 6 аудитор, 2 гэрээт ажилтан, зөвлөх үйлчилгээний гэрээгээр ажилласан 3 хувийн аудитын компаний 8 ажилтан, 2 хянан удирдах ажилтан нийт 18 ажилтан 5027.0 цаг, 636.0 хүн өдөр ажиллан аудитыг дуусгав.



Аудитаар 3025.4 сая төгрөгийн алдааг илрүүлэн 361.3 сая төгрөгийн алдааг залруулан тайлан гаргуулсан, залруулаагүй алдааны 2065.9 сая төгрөгийн алдаа нь СХС-ийн хугацаа хэтэрсэн зээл эзэлж байна.

Илэрсэн алдааг зардлын зүйлээр авч үзвэл:

*Хүснэгт-24*

Нийт хөрөнгө	Төсөвт зардлын гүйцэтгэл	Аудитаар илрүүлсэн зөрчил дутагдлын дүн мян/төг	Үүнээс						Илрүүлсэн зөрүүг санхүүгийн тайланд залруулсан эсэх
			Үр дүнгийн тайланд гарсан зөрчил мян/төг	Мөнгөн гүйлгээ -ний тайланд гарсан зөрчил мян/төг	Өмчийн өөрчлөлтийн тайланд гарсан зөрчил мян/төг	Санхүүгийн байдлын тайланд гарсан зөрчил мян/төг	Санхүүгийн тодруулгад гарсан	Бусад	
96.6	61.3	3,025.4	123.8	58.2	98.4	135.1	36.7	2,573.2	361.3

Нийт илэрсэн алдааг дараахь байдлаар шийдвэрлэв.

*Хүснэгт-25*

Алдаа, зөрчлийн ангилал															
Аудитаар өгсөн зөвлөмж		Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн залруулга		Аудитын явцад тогтоосон төлбөрийн акт		Аудитын явцад өгсөн албан шаардлага		Албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		Бусад		Аудитын илэрсэн нийт алдаа, зөрчлийн дүн	
Тоо	Дүн /сая .төг/	Тоо	Дүн /сая .төг/	Тоо	Дүн /сая .төг/	Тоо	Дүн /сая .төг/	Тоо	Дүн /сая .төг/	Тоо	Дүн /сая .төг/	Тоо	Дүн /сая .төг/	Тоо	Дүн /сая .төг/
124	413.5	66	361.3	30	28.7	48	2146.5	1	45.6	0	0	1	75.4	270	3071.1

Илэрч байгаа алдаанд дүгнэлт хийж үзэхэд: Сумдын орон нутгийн байгууллагууд өр, авлагын мэдээгээ зөв өгдгүй, төрийн сангаас өр авлагын мэдээг үндсэн баримттай тулган баталгаажуулж үзэлгүйгээр өр барагдуулах санхүүжилтийг нэмж тодотгон өгдөг нь зөрчилтэй байна.

Тухайлбал: Тэс сумын ЗДТГ-т өрийн мэдээг үндэслэн жилийн эцэст 32.0 сая төгрөгийн өр барагдуулах нэмэлт санхүүжилтийг олгосон байна. Аудитын явцад дээрх санхүүжилтийг хянаж үзэхэд ЗДТГ-нь илүү орон тоо ажиллуулсан, мөн ажилтнуудад нийт 30.9 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож 16.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн, олгосон урьдчилгааг сар бүр суутган тооцоо хийгээгүй, 4.5 сая төгрөгийг авлагыг бүртгэлд тусгаагүй бусад бараа үйлчилгээний зардалд шууд хаалт хийж мөнгөн хөрөнгө завших, ашиглан бий болох нөхцөлийг бүрдүүлсэн зөрчил илэрсэн бөгөөд аудитын явцад цалингийн урьдчилгааг тулган баталгаажуулан 9.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

**ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн талаар**

Аудитаар ТЕЗ-ийн харьяа байгууллага, сумдын ТЕЗ-ийн нийт 257 санхүүгийн тайланд хийсэн аудитаар 135 тайланд зөрчилгүй, 95 байгууллага түүвэр, 22 итгэл, 4 байгууллагад сөрөг, хязгаарлалттай 1 санал дүгнэлт өгөгдсөн байна.

**Арван дөрөв. Аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт**

Аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлогын 94786.3 сая төгрөгийг суурь болгон авч түүний 1.0 хувиар тооцон 947.8 сая төгрөгөөр тогтоов.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд нийт 3025.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 361.3 сая төгрөгийг залруулан тайлан гаргуулсан бөгөөд Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн 2,065.9 сая төгрөгийн алдааг чанарын хувьд материаллаг биш гэж үзсэн бөгөөд 598.2 сая төгрөгийн алдаа нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” дүгнэлтийг оруулж байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

### АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. 2017 онд орон нутгийн татварын орлогыг аймгийн ИТХ-ын 2016.12.02-ны өдрийн хуралдааны 19 тоот тогтоолоор 138.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 7562.0 сая төгрөгөөр баталж, 9337.7 сая төгрөгийн орлого оржээ.
2. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2017.06.09-ны өдрийн 21 тоот тогтоолоор 2016 оны жилийн эцсийн үлдэгдэл 723.1 ая төгрөгийн орлогыг тодотгон баталсан байна.
3. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2017.12.04-ны өдрийн 29 тоот тогтоолоор орон нутгийн байгууллагуудын санхүүжилтийн орлогыг 1121.5 сая төгрөгөөр, тусгай шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийн орлогыг 1880.1 сая төгрөгөөр нийт 3001.4 сая төгрөгөөр орлого, зардлыг тодотгон баталсан байна.
4. Орон нутгийн татварын орлогын төлөвөлгөө 123.4 хувиар буюу 1775.7 сая төгрөгөөр давж биелсэн, татварын давсан орлогыг нэр төрлөөр тодотгон баталж өгөөгүй зардлыг тодотгон баталсан байна.
5. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 2146.2 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 1379.4 сая төгрөг оруулж орлогын төлөвлөгөө 766.8 сая төгрөгөөр тасарч энэ нь аймгийн нийт орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн байна.
6. Сумдын санхүүгийн алба Төсвийн тухай хуулийн 66.1.4 “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх” гэсэн заалтын дагуу сумын ИТХ-ын хуралдааны төсөв баталсан тогтоолыг цаг хугацаанд нь бүрэн ирүүлээгүйгээс 18 сум татварын орлогыг 226.1 сая төгрөгөөр нэмж сумын ИТХ-ын хуралдаанаар тодотгосон байхад аймгийн Татварын хэлтсийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй
7. Аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар батлагдсан төсөвт зардлыг төлөвлөгөөнөөс 3,2 % буюу 1977.8 сая төгрөг хэмнэж, орон нутгийн төсвийн байгууллагууд 362.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.
8. 2017 оны гүйцэтгэлээр нийт ажилчдын тоо 57 орон тоогоор илүү ажиллаж байна.
9. Сумдын эргэлтийн эмийн сангууд орон нутгийн өмчид суурилсан хуулийн этгээдийн статусаар ажиллаагүй, гэрчилгээ тамга, тэмдэггүй, санхүүгийн тайлан гаргаж Эрүүл мэндийн газарт нэгтгүүлдэггүй, банкинд тусгай дансгүй, НББ-ийн бүртгэл, данс журнал хөтлөөгүй зэрэг зөрчил, дутагдалтай байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч Д.Батсайхан,  
аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга  
Ж.Хүрэлбаатар нар танаа

Завхан аймгийн төсвийн Ерөнхийлөн, төвлөрүүлэн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийсэн дүнд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

1. Аймгийн орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь бодитой төлөвлөж, Төсвийн тухай хуулийн 34.2 дахь заалтыг хэрэгжүүлэх, аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтэс сумдын санхүүгийн албанаас төсөв баталсан, тодотгосон шийдвэрийг тухай бүр нь авч, орлого, зарлагын төлөвлөгөөний нэгтгэлийг хийх, жилийн эцэст төсвийн мэргэжилтэнтэй тодотгосон төсвийн хуваарийг байгууллага бүрээр нийлж улсын болон орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтийг тулган баталгаажуулж байх, Төсвийн тухай хуулийн 66.1.4 дэх заалтыг мөрдөж ажиллах,
2. Төсвийн тодотголыг хийхдээ орон нутгийн татварын орлогыг нэр төрлөөр нь тодотгон баталж байх,
3. Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын өр, авлагын мэдээг үндсэн баримтын хамт нягтлан үзэж нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэж байх,
4. Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоол "Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" –ын хэрэгжилтийг хангуулж ажиллах,
5. Шилэн дансны хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн байгууллагын холбогдох албан тушаалтанд хариуцлага ногдуулан ажиллах,
6. Аймгийн төрийн санд бүртгэлтэй 153.7 сая төгрөгийн, аудитын газрын зөвлөмжөөр үүсгэсэн 87.8 сая төгрөгийн авлага, Төрийн сангийн 41.6 сая төгрөгийн өглөгийг судалж барагдуулах, тодорхой ажил зохион байгуулах,
7. Сумдын СХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага 2065.9 сая төгрөгийг барагдуулах талаар сумдын Засаг дарга нарт чиглэл өгч ажиллах,
8. 2017 оны гүйцэтгэлээр нийт ажилчдын тоо 57 орон тоогоор илүү ажиллаж байгааг нягтлан батлагдсан орон тоонд ажиллах
9. Сумдын эргэлтийн эмийн сангуудын илэрсэн алдаа дутагдалд дүгнэлт хийж цаашид Орон нутгийн өмчид суурилсан хуулийн этгээдээр ажиллах эсэхийг холбогдох дээд байгууллагуудтай хамтран шийдвэрлэх

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/06.

Улиастай

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтууд, Монгол улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 тоот тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны нэгтгэсэн тайланг баталгаажуулсугай.
2. Санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг дүгнэлтийн хамт төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсүгэй.
3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч түүний үр дүнг 2018 оны 12 сарын 01-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан тоотоор ирүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч, Аймгийн Засаг дарга /Д.Батсайхан/-д зөвлөсүгэй.
4. Аудитын тайланд тусгагдсан менежментийн захидлаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2018 оны 12 дугаар сарын 15-ны дотор багтаан удирдлагын зөвлөлд танилцуулахыг ахлах аудитор /Б.Дагвасүрэн/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.УЛАМБАЯР

152 091